



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 175
танай _____ ны № _____ т

Г САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН Г
АЛБАНЫ ДАРГА Б.БАТТУЛГА
ТАНАА

Төрийн аудитын газраас танай байгууллагын
2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах
аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 895.8 мянган төгрөгийн 1 албан
шаардлага, 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны
06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн
хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030170



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүү хяналт аудитын албаны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээлбэл зохих мэдээллээс 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	14
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.08.24 № 174
танай _____ ны № _____ т

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА Б.БАТТУЛГА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнүүлэн гүйцэтгэлийн үнэлгээгээр 86.5 хувьтай үнэлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 18 нэр төрлийн 10,052.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

006020207

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,936,500.00	2,542,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,936,500.00	2,542,200.00
354	Хангамжийн материал	2,936,500.00	2,542,200.00
35410	Бичиг хэргийн материал	1,213,000.00	637,600.00
35420	Аж ахуйн материал	1,313,500.00	1,904,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	410,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,323,310.49	14,752,936.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,323,310.49	14,752,936.43
392	Биет хөрөнгө	8,323,310.49	14,752,936.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,444,444.72	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,444,444.72)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,200,000.00	16,019,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,930,566.71)	(6,793,616.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,774,900.00	8,007,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,721,022.80)	(2,480,346.68)
39301	Программ хангамж	300,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,259,810.49	17,295,136.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	17,295,136.43
51	Засгийн газрын хувь оролцоо	-	17,295,136.43
512	Хуримтлагдсан үр дүн	-	17,295,136.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-	11,259,810.49
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,035,325.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	17,295,136.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	146,493,200.00	174,122,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	850,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	850,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	850,000.00
122	Тусламжийн орлого	-	150,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	150,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,493,200.00	173,122,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	146,493,200.00	173,122,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	146,493,200.00	173,122,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	145,333,304.81	168,086,974.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,333,304.81	168,086,974.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,275,585.20	166,568,023.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,684,644.60	113,023,511.88
210101	Үндсэн цалин	68,369,670.93	79,511,999.86
210102	Нэмэгдэл	26,705,910.15	24,963,355.04

210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,354,729.36	4,388,998.13
210104	Урамшуулал	533,537.86	4,159,158.85
210105	Гэрээт ажлын хөлс	720,796.30	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,987,945.79	13,310,147.69
210201	Тэтгэврийн даатгал	8,680,769.79	9,712,459.30
210202	Тэтгэмжийн даатгал	1,126,987.32	1,006,876.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	684,212.68	914,113.80
210204	Ажилгүйдлийн даатгал	203,900.00	152,427.10
210205	Эрүүл мэндийн даатгал	1,292,076.00	1,524,270.70
2104	Хангамж, бараа материалын зардал	6,684,280.00	8,508,129.87
210401	Бичиг хэрэг	1,110,500.00	1,403,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,750,000.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	488,780.00	689,829.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	414,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	335,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,585,000.00	4,228,300.00
210604	Урсгал засвар	7,585,000.00	4,228,300.00
2107	Томилолт, зочны зардал	11,975,000.00	21,946,100.00
210702	Дотоод албан томилолт	11,975,000.00	21,946,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,642,410.00	1,202,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,050,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	65,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,960.00	65,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,716,304.81	4,348,874.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	360,000.00	726,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,356,304.81	3,622,374.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,057,719.61	1,518,950.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,894,600.00	1,391,111.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	951,111.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,894,600.00	440,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	163,119.61	127,839.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	163,119.61	127,839.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,159,895.19	6,035,325.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,159,895.19	6,035,325.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	146,493,200.00	173,122,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,493,200.00	173,122,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	146,493,200.00	173,122,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	146,493,200.00	173,122,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	142,546,200.00	163,920,300.00

/Төгрөгөөр/

21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,546,200.00	163,920,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,488,480.39	162,401,349.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,684,644.60	113,023,511.88
210101	Үндсэн цалин	67,339,239.06	79,511,999.86
210102	Нэмэгдэл	27,768,707.57	24,963,355.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,188,671.81	4,388,998.13
210104	Урамшуулал	-	4,159,158.85
210105	Гэрээт ажлын хөлс	1,388,026.16	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,987,945.79	13,310,147.69
210201	Тэтгэврийн даатгал	8,680,769.79	9,712,459.30
210202	Тэтгэмжийн даатгал	995,700.00	1,006,876.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	815,500.00	914,113.80
210204	Ажилгүйдлийн даатгал	203,900.00	152,427.10
210205	Эрүүл мэндийн даатгал	1,292,076.00	1,524,270.70
2104	Хангамж, бараа материалын зардал	7,743,480.00	7,932,729.87
210401	Бичиг хэрэг	1,999,700.00	828,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,750,000.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	493,780.00	689,829.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	414,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,995,000.00	3,813,400.00
210604	Урсгал засвар	7,995,000.00	3,813,400.00
2107	Томилолт, зочны зардал	11,975,000.00	21,946,100.00
210702	Дотоод албан томилолт	11,975,000.00	21,946,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,642,410.00	1,202,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,050,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	65,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,960.00	65,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	460,000.00	1,172,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	460,000.00	1,172,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,057,719.61	1,518,950.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,894,600.00	1,391,111.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	951,111.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,894,600.00	440,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	163,119.61	127,839.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	163,119.61	127,839.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,947,000.00	9,202,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,947,000.00	9,202,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,947,000.00	9,202,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,947,000.00	9,202,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,947,000.00	9,202,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,947,000.00)	(9,202,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагд- сан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	-	-	10,099,915.30	10,099,915.30
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	10,099,915.30	10,099,915.30
3	Тайлант үеийн үр дүн	-	-	1,159,895.19	1,159,895.19
4	2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	-	-	11,259,810.49	11,259,810.49
5	2022 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	-	-	11,259,810.49	11,259,810.49
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	11,259,810.49	11,259,810.49
7	Тайлант үеийн үр дүн	-	-	6,035,325.94	6,035,325.94
8	2022 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	-	-	17,295,136.43	17,295,136.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	175,122,300.00	172,994,460.44	2,127,839.56	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	175,122,300.00	172,994,460.44	2,127,839.56	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	173,622,300.00	171,603,349.44	2,018,950.56	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,058,000.00	113,023,511.88	34,488.12	100.0
210101	Үндсэн цалин	79,752,600.00	79,511,999.86	240,600.14	99.7
210102	Нэмэгдэл	28,083,100.00	24,963,355.04	3,119,744.96	88.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,005,000.00	4,388,998.13	616,001.87	87.7
210104	Урамшуулал	217,300.00	4,159,158.85	(3,941,858.85)	1,914.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,631,600.00	13,310,147.69	321,452.31	97.6
210201	Тэтгэврийн даатгал	9,602,300.00	9,712,459.30	(110,159.30)	101.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,132,300.00	1,006,876.79	125,423.21	88.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	905,800.00	914,113.80	(8,313.80)	100.9
210204	Ажилгүйдлийн даатгал	226,500.00	152,427.10	74,072.90	67.3
210205	Эрүүл мэндийн даатгал	1,764,700.00	1,524,270.70	240,429.30	86.4

2104	Хангамж, бараа материалын зардал	9,100,000.00	7,932,729.87	1,167,270.13	87.2
210401	Бичиг хэрэг	1,750,000.00	828,400.00	921,600.00	47.3
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	850,000.00	689,829.87	160,170.13	81.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	414,500.00	85,500.00	82.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,229,500.00	13,015,400.00	214,100.00	98.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,229,500.00	9,202,000.00	27,500.00	99.7
210604	Урсгал засвар	4,000,000.00	3,813,400.00	186,600.00	95.3
2107	Томилолт, зочны зардал	22,100,000.00	21,946,100.00	153,900.00	99.3
210702	Дотоод албан томилолт	22,100,000.00	21,946,100.00	153,900.00	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,203,200.00	1,202,960.00	240.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,050,000.00	1,050,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	65,100.00	65,000.00	100.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,100.00	65,960.00	140.00	99.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,300,000.00	1,172,500.00	127,500.00	90.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,172,500.00	127,500.00	90.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,391,111.00	108,889.00	92.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,391,111.00	108,889.00	92.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	951,111.00	48,889.00	95.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	440,000.00	60,000.00	88.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	175,122,300.00	173,122,300.00	2,000,000.00	99.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	175,122,300.00	173,122,300.00	2,000,000.00	99.8
132001	Орон нутгийн төсвөөс	175,122,300.00	173,122,300.00	2,000,000.00	99.8
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5	5	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5	5	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Санхүүгийн хяналт аудитын алба нь эрхэм зорилгоо “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр шалгагдсан тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааны хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлсэн, 74 байгууллагад хяналт шалгалт хийж, улсын ахлах байцаагчийн 71 төлбөрийн актаар 34,626.3 мянган төгрөгийн төлбөр тогтоож, 56,405.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 26 албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт аудитын алба нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,035.3 мянган төгрөгөөр буюу 53.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2,936.50	2,542.20	(394.30)
Үндсэн хөрөнгө	8,323.31	14,752.94	6,429.63
Нийт хөрөнгө	11,259.81	17,295.14	6,035.33
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	17,295.14	17,295.14
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	17,295.14	17,295.14

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь үндсэн хөрөнгийн данс өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс өссөн шалтгаан нь 3 нэр төрлийн тавилга эд хогшлыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн 03 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн даргын А/07 дугаар тушаалаар үнийг шинэчлэн тогтоож, А/13 дугаар тушаалаар Прадо-120 маркийн 29-00БУЛ улсын дугаартай авто машиныг данс бүртгэлээс хассан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 178,500.0 мянган төгрөгийн бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаар зардлыг 3,377.7 мянган төгрөгөөр, 175,122.3 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд 2 удаа төсөвт өөрчлөлт оруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 175,122.3 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр 173,122.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 172,994.5 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2,127.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 175,122.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,626.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,970.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээлбэл зохих мэдээллээс 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/106 дугаар албан тоотой тус тус ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	2	-	2	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын зарцуулалт болон төрийн үйлчилгээний албан тушаалтанд олгосон үр дүнгийн урамшууллыг балансын урамшуулал хэлбэрээр давхардуулан олгосон талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,150.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 24,254.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 895.8 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 895.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгч ажиллалаа.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас байгууллагын даргын 2022 оны А/13 дугаар тушаалаар нягтлан бодогч Д.Сарангэрэлд нэг сарын үндсэн цалингаар балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангуулан зарцуулж, алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бичиг хэргийн материал болох бичгийн цаасыг бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримтыг үндэслэж, орлогод авч тайлагнаагүй, материалын тайлангийн хөдөлгөөн нь бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн тооцооны үлдэгдлийн баталгаа болон, шаардах хуудсаар гаргасан зарцуулалтын дүн бараа материалын тайлантай зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-ыг мөрдөж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгчийн ирүүлсэн анхан шатны баримтыг үндэслэж орлогод авч, зарцуулж ажиллах.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдлийг олгохдоо үнэлсэн гэх боловч сарын эхэнд тушаал гаргаж олгосон. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нэмэгдэл олгох журам"-ын 4 дүгээр хавсралтыг мөрдөж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан "ТҮ-ий албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэсэн.	1	24,254.6			1	24,254.6						
Дүн	1	24,254.6			1	24,254.6						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас байгууллагын даргын 2022 оны А/13 дугаар тушаалаар нягтлан бодогч Д.Сарангэрэлд нэг сарын үндсэн цалингаар балансын урамшууллыг үр	1	895.8	-	-	1	895.8	-	-	-	-	-	-

дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.												
Ур чадварын нэмэгдлийг олгохдоо үнэлсэн гэх боловч сарын эхэнд тушаал гаргаж олгосон.	1	-				1	-					
Бэлтгэн нийлүүлэгчийн ирүүлсэн анхан шатны баримтыг үндэслэж орлогод авч, зарцуулж ажиллах.	1	-				1	-					
Дүн	3	895.8	-	-	1	895.8	2	-	-	-	-	-



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 01/159

Булган сум

А0670253

БҮА-2023/166/НА - СТА-ТНБ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардалд нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд байгууллагын даргын А/13 дугаар тушаалаар нягтлан бодогч Д.Сарангэрэлд нэг сарын үндсэн цалин 895,797.00 (найман зуун ерэн таван мянга долоон зуун ерэн долоо) төгрөгийн балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” заалтыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон алдаа зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.

006040516

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга (Б.Баттулга), нягтлан бодогч (Д.Сарангэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ
АУДИТЫН МЕНЕЖЕР  Ж.ЭНХЦООДОЛ
АУДИТОР  Г.ЦЭРЭНЛХАМ

